

2023 оны 03 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар: 23/08

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 62, 64, 65, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.
 - 2.2. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах.
3. Компани нь сүүлжийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй тул Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2022 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
4. Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд өдөр тутмын сонин хэвлэл болон телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг брокер дилерийн компаниудад 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор дамжуулан тараахыг зөвшөөрсүгэй.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1

тоот хаягт буюу “Номин юнайтед” цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга М.Өлзийбатыг томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Эдийн засагч Өлзийсайханы Оюун-Эрдэнэ, тооллогын комиссын гишүүдээр хуульч Энхболдын Төгсжаргал, хуульч Батмөнхийн Сансар нарыг томилсугай.
12. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх Ч.Үржинбадамыг, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Няглан бодогч Ж.Пүрэвжаргал нарыг томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.ШАГДАРСҮРЭН



“Хөвсгөл усан зам” ХК-ийн 2023.04.20-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас

- Хурал хуралдах газар /хаяг, байршил/: Хурал цахим хэлбэрээр болно.
 - Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:
 - Хувьцааны тоо: Регистр №
 - Хурлаар шийдвэрлэх асуудлүүд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах.

а. Зөвшөөрсөн б. Татгалзсан в. Түдгэлzsэн

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг батлах.

а. Зөвшөөрсөн б. Татгалзсан в. Түдгэлэсэн

Санамж:

1. Санал өгөгч нь өгөх саналынхаа өмнөх үсгийг дугуйлна.
 2. Саналын хуудсыг балласан, засварласан бол хүчингүйд тооцно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

2023/ /

Саналын хуудсыг хүчинтэй / хүчингүйд (доогуур нь зурах) тооцсон:

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд:

Гишүүд:

ХӨВСГӨЛ УСАН ЗАМ ХК

Хөвсгөл, Хатгал, 1-р хэсэг, Хатгал тосгон.
Улаанбаатар оффис, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Гутал ХК байр.
Утас: 976 7577-8888, 8888-3550
И-мэйл: urjinbadam.ch@nomin.net
Вэб: www.nomin.mn

2023 оны 03 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар: 23 / 09

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг,
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хурлын
шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж
дүгнэсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар
хэлэлцүүлэн батлуулсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

А.ШАГДАРСҮРЭН

